Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.


Тус байгууллагад мөрдөж байгаа Эрүүл мэндийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2010 онд боловсруулсан бөгөөд төсвийн захирагчийн тушаалаар баталгаажуулаагүй, уг баримт бичигт тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,029,928.1 мянган төгрөгөөр бууу 5.9 хувиар өссөн байна.



Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт



Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	77,910.9	10,384.0	(67,526.9)
Авлага	499,555.0	-	(499,555.0)
Бараа материал	213,740.1	523,137.6	431 309,397.5
Үндсэн хөрөнгө	16,651,084.0	17,938,696.5	1,287,612.5
Нийт хөрөнгө	17,442,290.0	18,472,218.1	1,029,928.1
Өр төлбөр	1,357,639.0	506,278.1	(851,360.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	16,084,651.0	17,965,940.0	1,881,289.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	17,442,290.0	18,472,218.1	1,029,928.1

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 10,384.0 мянган төгрөг болж 67,526.9 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 77,236.7 мянган төгрөгийг тайлант оны эм, эмнэлгийн хэрэгсэлд зарцуулснаас шалтгаалсан байна.

Авлагын данс оны эхэнд 499,555.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан боловч оны эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан нь ЭМДС-аас авах санхүүжилтийг бүрэн авснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 523,137.6 мянган төгрөг болж 309,397.5 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 2,702,702.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан,
- Глобал сангаас 12,089.9 мянган төгрөгийн эм, тариа, ЭМГ-аас 181,193.6 мянган төгрөгийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ЭМЯ/НҮБ, ХАС/-аас 88,809.7 мянган төгрөгийн ковидын тест, эм тариа, аймгийн ЗДТГ-аас 3,160.0 мянган төгрөгийн оношлуур, Илдэн гүн хошуу ХХК-аас 30,844.8 мянган төгрөгийн оношлуур, МЭИК-аас 678.9 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл, Проманс ХХК-аас 1,615.2 мянган төгрөгийн түлэх утас, ХӨСҮТ-өөс 59,571.6 мянган төгрөгийн оношлуур зэрэг нийт 377,963.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, аймгийн ОНХС-аар хийгдсэн 47,630.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүчилтөрөгчийн систем авах, суурилуулах” төсөл, арга хэмжээг тус тус үнэ төлбөргүй хүлээн авсан,
- 2,867,512.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 523,137.6 мянган төгрөг болж, 309,397.5 мянган төгрөгөөр өсөхөд дараах ажил, гүйлгээ нөлөөлсөн байна. Үүнд:

- 47,630.0 мянган төгрөгийн хүчилтөрөгчийн зэс хоолой, гепарин тариа 10,937.9 мянган төгрөг, дексаметазон тариа 20,267.4 мянган төгрөг, комбинзон 24,869.8 мянган төгрөг, ремдесвир тариа 33,218.7 мянган төгрөг, N95 маск 11,619.5 мянган төгрөг, тамифлю эм 10,640.7 мянган

төгрөг, тазобактан эм 42,750.0 мянган төгрөг, ковидын тест 48,981.7 мянган төгрөг, тоцилизумаб 42,750.0 мянган төгрөг зэрэг эмүүдийг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 20,306,984.3 мянган төгрөг болж, 1,570,955.3 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:



- Төсвийн хөрөнгөөр 42,811.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан,
- Аймгийн ОНХО-аар 39,050.0 мянган төгрөгийн чих хамар хоолойн кабинетын лорын дурангийн иж бүрдэл,
- ЭМЯ-аас 1,270,476.9 мянган төгрөгийн эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааны тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 117,050.0 мянган төгрөгийн эмнэлгийн ор, шүүгээ, 157,637.2 мянган төгрөгийн бүрэн тоноглогдсон Landcruiser 78 автомашин, Денкфарм ХХК-аас дэмжих төвд 1,150.0 мянган төгрөгийн ус цэвэршүүлэгч ирүүлснийг хүлээн авсан,
- 57,220.7 мянган төгрөгийн 2 тээврийн хэрэгслийг аймгийн ОНӨГ-ын даргын 2022 оны 03 дугаар 28-ны 109, 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 192 дугаар тушаалаар акталж, устгасан,
- Байгууллагын даргын 2022 оны 47 дугаар тушаалыг үндэслэн ашиглалтын хугацаа дууссан 3,725,861.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын ашиглах хугацааг сунгасан гэх мэт.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 506,278.1 мянган төгрөг болж 851,360.9 мянган төгрөгөөр буурсан нь 2021 оны эцэст тайлагнагдсан 1,357,640.0 мянган төгрөгийн өр төлбөрийг ЭМС-ын тушаалаар ирсэн санхүүжилтээр барагдуулсан, тайлант оны ЭМДС-аас авах санхүүжилтийн авлагаас төлж барагдуулах өр төлбөрийг барагдуулснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 17,965,940.0 мянган төгрөг болж 1,881,289.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС-аас 10,225,027.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 78,282.7 мянган төгрөг, нийт 10,303,310.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130020402 дугаар дансанд аймгийн ЗДНХ-өөс 1,000.0 мянган төгрөг, ЭМГ-аас 11,270.9 мянган төгрөгийн ковидын илүү цагийн хөлс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 31,825.9 мянган төгрөг, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 77,236.7 мянган төгрөг зэрэг нийт 121,333.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг дараах зардлуудад зарцуулж, үлдэгдэл 3,762.5 мянган төгрөгийг үндсэн данс руу төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Цалин, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардалд 8,075.5 мянган төгрөг,
- Хангамж бараа материалын зардалд 1,630.2 мянган төгрөг,
- Нормативт зардалд 55,002.7 мянган төгрөг,
- Эд хогшил худалдан авах зардалд 32,850.2 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 8,910.0 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардалд 10,800.0 мянган төгрөг,
- Урсгал шилжүүлэгт 4,065.0 мянган төгрөг гэх мэт.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.



Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 42 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 12,351,746.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 123,517.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 92,638.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус эмнэлэг нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 305,026.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 114,735.0 мянган төгрөг, нормативт зардлыг 381,131.8 мянган төгрөг зэрэг нийт **848,362.1** мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 15,520.5 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээ, 140,064.7 мянган төгрөгийн зарлагын 9 гүйлгээний /цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ/ мэдээллийг огт мэдээлээгүй бөгөөд мэдээлсэн байдлын хэрэгжилт 90.9 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,461.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 27,626.6 мянган төгрөгийн албан шаардлага, 49,020.9 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөнөөс 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,461.0	1	1,461.0	100.0
Албан шаардлага	2	27,626.6	2	27,626.6	100.0
Зөвлөмж	4	49,020.9	3	15,100.9	75.0

/мянган төгрөгөөр/

Нийт дүн	7	78,108.5	6	44,188.5	85.7
----------	---	----------	---	----------	------

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудит болон дараагийн аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Тус төсвийн шууд захирагчийн шийдвэрээр бус ЭМС-ын 2022 оны А/380 дугаар тушаалын дагуу 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан дарга Ц.Эрдэнэчимэг, ахлах нягтлан бодогч Ц.Энх-Оюун нарт тус бүр 3 сар, санхүү бүртгэлийн ажилтнуудад тус бүр 1 сарын үндсэн цалингаар тооцож, 9 албан хаагчид нийт **12,381.4** мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно, 15.1.3: Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Тайлант онд ЭМДЕГ-тай байгуулсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-ний 2.4.2-т “төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглабартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар саруудад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгон хуанлийн 2 хоногт багтаан илгээх, 11-ний өдрөөс тухайн сар дуустал хугацаанд үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэлтэй хамтатган хүргүүлэх” гэж заасныг мөрдлөг болгон ЭМДС-аас авах 12 дугаар сарын 11-ээс 31-ныг хүртэлх хугацаанд үзүүлсэн тусламж үйлчилгээний авлага болох 521,118.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгаар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2: “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Цаашид дээрх хууль тогтоомжуудыг мөрдөж, санхүүгийн тайланд тухайн төсвийн жилд үзүүлсэн үйлчилгээний авлагыг бүрэн тусгах шаардлагатай байна.

3. Шатлалын эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журмыг ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолоор баталсан боловч зарцуулалт, тайлагнал, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй байхад санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, цалинг гүйцэтгэл, үр дүнд суурилан нэмэгдүүлэх гэх үндэслэлээр эрүүл мэндийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр буюу тус эмнэлгийн даргын 2022 оны Б/96 дугаар тушаалаар үндсэн цалингийн доод жишгийг 05 дугаар сараас эхлэн 10 хувиар нэмэгдүүлснээс шалтгаалан нийт **65,960.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.**

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг, төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” журмын 2 дахь “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг салбарын онцлог болон албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан нэмэгдүүлж олгох асуудлыг зохицуулахад чиглэсэн арга хэмжээг батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй”, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” журмын 8.3.5 дахь “Төсвийн хувьд хагас бие даасан тогтолцоонд шилжин ажиллах, ... тусламж, үйлчилгээний санхүүжилтийн зарцуулалтын сахилга бат, хариуцлагыг чангатгах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид эрүүл мэндийн салбарын үйлчилгээний албан тушаалтнуудын цалингийн доод жишгийг ЭМС-ын тушаал, шийдвэрийг үндэслэн нэмэгдүүлж байх нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 47,630.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Тайлант хугацаанд аймгийн ОНХС-аар хийгдсэн 47,630.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүчилтөрөгчийн систем авах, суурилуулах” төсөл, арга хэмжээгээр хэрэгжсэн бараа материалуудыг эргэлтийн хөрөнгөд бүртгэж, шууд зардлаар тайлагнасан байсныг залруулж, бараа материалын үлдэгдлээр тусгууллаа.

Аудитаар нийт 125,719.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 332.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 82,086.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 43,299.5 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Эдийн засагч Н.Шинэзаяагийн хавсран ажилласны нэмэгдлийг ажилласан цагийн бүртгэлээс **332.9** мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулалгүйгээр **81,561.8** мянган төгрөгийн зардал гаргаж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Үүнд:

- Нормативт хоолны зардлаас байгууллагын ахмад настанд өгөх гарын бэлэгт **5,934.0** мянган төгрөг, сургалтын хоолны зардалд **627.8** мянган төгрөг зэрэг нийт 6,561.8 мянган төгрөгийг зарцуулсан,
- Өмнөх онд нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдлээр тайлагнагдсан ЭМЯ-ны санхүүжилтээр хийгдэх халдвартын тасгийн агааржуулалтын засварын ажлын **75,000.0** мянган төгрөгийг тайлант оны эм, эмнэлгийн хэрэгслийн төлбөрт шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд төсвийн зохицуулалт хийлгэх албан шаардлага хүргүүлэв.

2. 2021 оны санхүүгийн тайланд тусгаж, тайлагнаагүй **525.0** мянган төгрөгийн вакцины хатгалтын хөлсийг тайлант оны зардлаас төлж барагдуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.3. бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5. “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтад үндэслэн ажил гүйлгээ, өр төлбөрийг үнэн зөв бүртгэж, бүртгэл, тайланд тусгах, авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэх.

3. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажуагүй худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвалзохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт **43,299.5** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- 4,640.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын жолоочийн тооцооны хуудсын үзүүлэлтүүдийг бүрэн хөтлөөгүй, 100 км-т зарцуулах жишиг нормыг бодит байдалд үндэслэн тооцож, тогтоогоогүй,

- Захиалгын хуудасгүйгээр 19,850.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг диализын тасаг болон дэмжих төв рүү зарцуулж, тайлагнасан,
- Шүдний материалын 17,553.4 мянган төгрөгийн зарцуулалтын тайланг гаргаагүй,
- Холбогдох албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр дарга Ц.Эрдэнэчимэгт 1,255.3 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал олгосон.



Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр "Жишиг норм батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүчин төгөлдөр, баталгаажсан анхан шатны баримтад үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэн, бүртгэл тайланд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		
							Тоо	Дүн	
"Бараа материалыг шууд зардлаар тайлагнасан	1	47,630.0	1	47,630.0			1	47,630.0	
Дүн	1	47,630.0	1	47,630.0			1	47,630.0	

/мянган төгрөгөөр/

Үүнээс

Заглуулсан

Тоо

Дүн

Тоо

Дүн

Тоо

Дүн

Тоо

Дүн

Тоо

Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хавсран ажилласны нэмэгдлийг илүү тооцож олгосон байна.	1	332.9	1	332.9								
Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй.	1	81,561.8			1	81,561.8						
2021 оны санхүүгийн тайланд тусгаж, тайлагнаагүй зардлыг тайлант оны зардлаас төлж барагдуулсан байна.	1	525.0			1	525.0						
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	-			1	-						

/мянган төгрөгөөр/

Үүнээс

Нийт зөрчил

Тоо

Дүн

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.	1	43,299.5				1	43,299.5		
Дүн	5	125,719.2	1	332.9	3	82,086.8	1	43,299.5	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс /мянган төгрөгөөр/
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй	11						
Дүн	11						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Дүн							
Нийт дүн	11						11
							155,585.2
							155,585.2